

**“АРХИНД ДОНТОХ ЭМГЭГЭЭР ӨВЧИЛСӨН ИРГЭДИЙГ ЭМЧЛЭХ САЛБАР
ДУНДЫН ЦОГЦ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГАА”-ны хүрээнд зохон байгуулсан арга хэмжээний тайлан**

Хэрэгжүүлэгч байгууллага:

- “Тогтвортой Санхүүжилт” НҮТББ
- “Эрүүл монгол хүн” хөтөлбөр

Байршил, хугацаа:

Өдөр	Цаг	Байршил
2025/10/06	09:00-18:00	@Туушин зочид буудал, 23 давхар
2025/10/07	09:00-18:00	
2025/10/08	09:00-18:00	@Централ парк оффис, 12 давхар
2025/10/09	09:00-18:00	
2025/10/10	09:00-18:00	@Тэрэлж

Зорилго:

Сүүлийн жилүүдэд сэтгэл зүйн эрүүл мэндийн асуудал, архинд донтох эмгэгийн нийгмийн сөрөг нөлөө өсч байгаа нь уг асуудлыг олон түвшинд, салбар дундын уялдаатайгаар шийдвэрлэх шаардлагыг бий болгож байна. Энэ хүрээнд Сэтгэл зүйн эрүүл мэндийн анхны тусламж (МНФА) хөтөлбөрийг Монгол Улсад нутагшуулах, соёлын онцлогт нийцүүлэх, анхны сургалтыг зохион байгуулах, олон нийтийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх зорилгоор 5 хоногийн үйл ажиллагааг зохион байгууллаа.

Зорилт:

1. Сэтгэл зүйн эрүүл мэндийн анхны тусламж (МНФА) хөтөлбөрийг Монгол Улсад нутагшуулах ажлын суурийг тавих, хөтөлбөрийн бүтэц, агуулгыг соёлын онцлогт нийцүүлэхэд чиглэсэн хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулах.
2. МНФА хөтөлбөрийн анхны сургалтыг зохион байгуулах, сургагч багш нарыг чадавхжуулах, сургалтын арга зүй, хэрэглэгдэхүүнтэй танилцуулах.
3. Сэтгэл зүйн эрүүл мэндийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголт, тусламж авах зан үйлийг сайжруулах, мэдээлэл түгээх болон нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх.
4. Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй хүн амын эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор архинд донтох эмгэгийн эсрэг салбар дундын арга хэмжээг сургалт, мэдээлэл, эмчилгээ, нөхөн сэргээх үйл ажиллагааг бүх талаар уялдуулан хэрэгжүүлэх.
5. МНФА хөтөлбөрийн цаашдын хэрэгжилтэд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг, оролцоог тодорхойлох, тогтвортой хамтын ажиллагааны сүлжээ байгуулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. MHFA хөтөлбөрийн танилцуулга, хэлэлцүүлэг зохион байгуулах

- MHFA International байгууллагын төлөөлөгчид хөтөлбөрийн зорилго, бүтэц, олон улсын туршлагыг танилцуулах.
- Монгол Улсын соёл, нийгмийн онцлогт нийцүүлэх чиглэлээр мэргэжлийн хэлэлцүүлэг хийх.

2. MHFA сургалт зохион байгуулах

- 2 хоногийн хугацаанд онолын болон дадлагын сургалт зохион байгуулж, оролцогчдыг сэтгэл зүйн анхны тусламжийн мэдлэг, ур чадвараар хангах.
- Сургагч багш нарын багийг бүрдүүлэх, сургалтын арга зүйг турших.

3. Олон нийтэд мэдээлэл түгээх, нөлөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх

- Сэтгэл зүйн эрүүл мэндийн талаарх мэдээлэл, зөвлөгөөг олон нийтийн сүлжээнд болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх.
- Тусламж авах зан үйлийг дэмжих уриалга, мессеж боловсруулах, түгээх.

Хамтран ажиллах байгууллага:

- СЭМҮТ
- АШУҮС

Санхүүжүүлэгч байгууллага:

- “Тогтвортой Санхүүжилт” НҮТББ
- Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв

Нээлтийн үйл ажиллагаа:

Монгол Улс Сэтгэлзүйн эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх (Mental Health First Aid – MHFA) олон улсын хөтөлбөрийг хэрэгжүүлэх албан ёсны эрхийг авсан 46 дахь орон болсныг саяхан зарлалаа.


Нээлтийн арга хэмжээнд төр, төрийн бус байгууллагууд, олон улсын түншүүд, сэтгэл зүйчид, эрүүл мэндийн ажилтнууд болон сайн дурынхан өргөнөөр оролцсон бөгөөд энэ үеэр **Australia Awards Mongolia** хөтөлбөрийн захирал **Л. Энхтүвшин** үг хэлж, Монгол Улсад сэтгэцийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, анхны тусламжийн ур чадварыг түгээн дэлгэрүүлэхэд энэхүү хөтөлбөрийн ач холбогдлыг онцоллоо.



Мөн **MHFA Mongolia** хөтөлбөрийн үүсгэн байгуулагч Л. **Мөнхзул** үг хэлж, хөтөлбөрийг Монголын соёлын онцлогт нийцүүлэн нутагшуулах ажлын чиглэл, цаашдын зорилго, сургалт, бэлтгэгдсэн сургагч багш нарын талаар танилцуулсан юм.

Нээлтийн арга хэмжээ нь Монгол Улсад сэтгэлзүйн анхны тусламжийн талаарх ойлголт, мэдлэгийг олон нийтэд түгээж, тусламж эрэх болон дэмжих соёлыг төлөвшүүлэхэд чухал эхлэл боллоо.

Контент/Сошиал постер

Хугацаа & Суваг	Материал	Тайлбар
<p>2025 /10/07</p> <p>Peak.mn #1</p>	   <p>Лео Зенг: MHFA хөтөлбөрийн үзэл санаа "Эрүүл Монгол хүн"-ий санаачилгатай нийцэж буй нь олзуурхуштай /Элчин сайд/</p>  	<p>Дэлхийн сэтгэцийн эрүүл мэндийн өдөрт: Сэтгэлзүйн эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх чадварт хүн бүр суралцъя! Сэтгэцийн эрүүл мэндийн Дэлхийн өдөр өнөөдөр тохиож байна. Үүнтэй зэрэгцээд манай улсад сэтгэцийн эрүүл мэндийн салбарт чухал алхмыг авчрах үйл явдлууд өрнөж байна. Энэ бол Монгол Улс Сэтгэлзүйн эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх /Mental Health First Aid/ олон улсын хөтөлбөрийг хэрэгжүүлэх албан ёсны эрхийг авсан 46 дахь орон болсныг саяхан зарласан явдал юм. Сэтгэлзүйн эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх сургалтын эрхийг Австрали улсаас эх орондоо өвөрлөн ирсэн эзэд нь Э.Мөнхзул, Б.Халиунаа нар. 🇺🇸 Тэд Австралийн Засгийн газрын “Australia awards” тэтгэлгийн төгсөгчид бөгөөд олон улсын хөгжил, хөгжлийн эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчнүүд. Эндээс харахад, Mental Healths First Aid /MHFA/ хөтөлбөр бол хүмүүст мэргэжил үл хамааран энэ чиглэлийн мэдлэг олгодог олон улсын хөтөлбөр юм. Э.Мөнхзул, Б.Халиунаа нар сэтгэлзүйн эрүүл мэндийг олон нийтийн боловсролын</p>



түвшинд хүргэх зорилгоор энэ төслийг гурван жилийн өмнөөс эхлүүлсэн байна.





Монгол Улс Сэтгэлзүйн эрүүл мэндийн анхны тусламж хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрхээ авсан **46 дахь орон** боллоо

Ажил дээр, эсвэл анги хамт олонд, гэр бүл дотор, найз төхдийн дунд хэн нэг маань “нэг л биш” байх шиг санагдах үе хааяа тохиолдож байсан уу. Яахаа мэдэхгүй, түүнд хэрхэн туслах аргаа олохгүй эргэлзэж тээнэгэлзэх үе байв уу?

Ийм тохиолдолд тухайн хүнийг шүүмжлэхгүйгээр сонсох, ярилцах гэх мэт арга замаар сэтгэлзүйн анхны тусламж үзүүлэн, зөв чиглүүлэх чадвар, мэдлэгийг хүмүүст эзэмшүүлдэг олон улсын хөтөлбөр байдаг аж.

2025
/10/07



Peak.mn
#2



2025
/10/07

Монцамэ


Монгол Улс “Сэтгэлзүйн эрүүл мэндийн анхны тусламж” хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрхтэй 46 дахь орон боллоо



2025/10-р сар

Сошиал маркетинг


01. Брендлого - Хөтөч - Стандарт - Хэрэглээ



02. Сошиал профайл болон ковер зураг



03. Видео болон зураг авалт



04. Эвентийн үеийн зураг авалт болон видео



1. Брендлого – Стандарт
2. Сошиал профайл болон ковер зураг
3. Видео зураг & Зураг авалт
4. Эвентийн үеийн зураг авалт
5. Бичлэг
6. ХЭВЛЭЛ

05. Хийгдсэн бичлэг



06. Хийгдсэн хэвлэлийн эх болон бусад

